



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	7
2.8.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	8
2.8.3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар;	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
3.1	Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал.....	11
3.2	Зардалтай холбоотой асуудал.....	12
3.3	Зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал	12
3.4	Санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал	13
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	14
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5	Хавсралт.....	18
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДЗШШТГ	Давж заалдах шатны шүүхийн тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СДШТГ	Сум дундын Шүүхийн тамгын газар
ШТГ	Шүүхийн тамгын газар
ЭХАШШТГ	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ЛҮНДЭНДОРЖ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.04.25 № 858
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



Аудитын тайлан

2.1. Оршил

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Н.Лүндэндорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн хөрөнгийн тооллогын үр дүнг баталгаажуулах, баримтжуулах, зардалтай холбоотой, зардлын эдийн засгийн ангиллыг баримтлах, санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргалтын чанарыг сайжруулах талаар зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөс 4 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж хариуцаж хэрэгжүүлэв.



Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 01/329 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”, түүнд тусгасан заавар аргачлалын дагуу горим сорилыг гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг хийлгэн, холбогдох нотлох зүйлсийг баталгаажуулан баримтжуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгон, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баталгаажуулж, А101 маягтаар баримтжуулсан болно.

Тус байгууллага 2018 онд “Шүүхийн хөгжлийн стратегийг тодорхойлох, хэргийн хөдөлгөөний удирдлагыг шинэ шатанд гаргах, ерөнхий шүүгч, тамгын газрын хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэмжих, шүүгчийн хөдөлмөрийг хэмжих аргачлалыг нэвтрүүлэх” зорилт дэвшүүлж ажилласан бөгөөд тайлант хугацаанд 6 зорилтын хүрээнд 103 арга хэмжээ төлөвлөж, 98 арга хэмжээ хэрэгжиж, 95.1 хувийн биелэлттэй байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын байгууллагуудын удирдлага төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд холбогдох хууль эрх зүйн акт болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд анхан болон давж заалдах шатны 114 шүүхийг хамарсан 39 шүүхийн тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, төвлөрсөн төсөв нийт 41 байгууллага хамрагдсан байна.



2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Э-тайлан” програм хангамж ашигладаг байна.

Үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөө багатай гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Шүүхийн ерөнхий зөвлөлийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, тайлагналтай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.



Нийт болон цэвэр хөрөнгө харьцангуй тогтмол үзүүлэлт, орлогын 94.7 хувийг улсын төсвийн санхүүжилт бүрдүүлдэг ба үйл ажиллагааны зардлын дүнгээс тооцох нь илүү бодитой, ажил гүйлгээний төрлийн эрсдэл, төлөвлөлтөөс хэтрэх, үр ашиггүй зардал гаргах зэрэг эрсдэлд өртөмтгий байх магадлалыг харгалзан нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 51,295.0 сая төгрөгийн 2 хувь буюу 1,025.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшин 3.5 сая төгрөгөөр хасагдсан нь 2018 оны жилийн эцсээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 175.3 сая төгрөгөөр хасагдсантай холбоотой байна.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтийн 2 хувиар тооцсон нь шинж чанар болон орчин нөхцлийн хувьд материаллаг шинжтэй зүйлс илрээгүй ба эрсдэл дунд гэж үзсэн болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 41 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдэхээс харьяа 30 шүүхийн тамгын газрын санхүүгийн тайланд аймаг, нийслэлийн төрийн аудитын газрууд аудит хийж, 6 шүүхийн тамгын газарт итгэл үзүүлж, 3 шүүхийн тамгын газар болон ажлын алба, төвлөрсөн төсвийг аудитын түүвэрт хамруулсан болно.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1. (Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр).

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	30	5	6	
	ДҮН	30	5	6	

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан.

Харьяа 30 шүүхийн тамгын газрын санхүүгийн тайланд аймаг, нийслэлийн төрийн аудитын газрууд аудит хийж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 36,215.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 98.3 хувь буюу 35,606.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 20.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.1 хувь буюу 30.8 сая төгрөгийн зөрчлийг



рилгах албан шаардлага өгч, 1.6 хувь буюу 558.1 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2. (Алдаа зөрчил, түүний шийдвэрлэлт, сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс: Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
		1	ТШЗ	41	208.9	14	20,2	8	30,8
2	ТЕЗ	4	400.2					4	400.2
Дүн		45	609.1	14	20.2	8	30.8	23	558.1

Эх сурвалж: Аудиторын гүйцэтгэсэн горим, сорилын баримтжуулалт

2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Харьяа шүүхийн тамгын газруудын санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн материаллаг хэмжээний, анхаарал татахуйц алдаа зөрчилтэй асуудлыг тоймлоход:

- Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан ЭХАШШТГ: Засгийн газрын 2013 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 68 дугаар тогтоолын заалтыг зөрчин 14.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн;
- Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр Дархан-Уул аймаг дахь ШТГ 6.0 сая, Төв аймаг дахь ШТГ 4.6 сая, нийт 10.6 сая төгрөгийг зарцуулсан;
- Ахмадын өдөр болон баяр ёслолд Баян Өлгий аймаг дахь ШТГ 7.4 сая төгрөгийг зарцуулсан;
- Баянхонгор аймаг дахь ШТГ: Төсвийг зохистой удирдаагүйгээс 6.8 сая төгрөгийн өр үүсгэсэн;
- Баян-Өлгий аймаг дахь ШТГ: 6.5 сая төгрөгийн ХХОАТ дутуу төлсөн;
- Өмнөговь аймаг дахь ШТГ: Цалингийн хэмнэлт 4.3 сая төгрөгийг Нийгмийн даатгалд шилжүүлэн авлага үүсгэсэн, сахилгын шийтгэл 6.5 сая төгрөгийг илүү суутгасан;
- Урсгал зардлаас Дархан-Уул аймаг дахь ДЗШШТГ 7.7, Дорноговь аймаг дахь ШТГ 1.5, нийт 9.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- Архангай аймаг дахь ШТГ: Төсвийн бодит бус хэмнэлтийн 1.5 сая төгрөгийг төвлөрүүлээгүй;
- Дорнод аймаг дахь ШТГ 1.4, Говь-Алтай аймаг дахь ШТГ 1.2, Булган аймаг дахь ШТГ 1.1, Говьсүмбэр аймаг дахь ШТГ 1.1, нийт 4.8 сая төгрөгийн цалин хөлс, албан томилолт илүү олгосон;
- Дорнод аймаг дахь ШТГ 1.1, Говьсүмбэр аймаг дахь ШТГ 1.0, Ховд аймаг Булган сум дахь СДШТГ 0.9, нийт 3.0 сая төгрөгийн бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн зэрэг зөрчлүүд аудитын тайланд дурдагдсан байна.

2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар;

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцсон.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Шүүхийн ерөнхий зөвлөлийн төвлөрсөн төсөв, Нийслэлийн давах шатны шүүхийн тамгын газар, Захиргааны хэргийн давах шатны шүүхийн тамгын газрын санхүүгийн баримттай танилцаж амжаагүйг 2019 оны завсарын аудитаар авч үзэхээр шийдвэрлэсэн, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Шүүхийн ерөнхий зөвлөл 6 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 48,604.8 сая төгрөгийн төсөв зарцуулах, үүний 48,544.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 60.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсвөөс 48,107.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 10.6 сая төгрөгөөр давуулжээ.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 48,108.8 сая төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь урсгал шилжүүлэг 215.3, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 97.7, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 67.9, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 53.8, хангамж, бараа материалын зардал 21.6, томилолт, зочны зардал 16.3, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 12.7, бараа үйлчилгээний бусад зардал 9.3, эд хогшил, урсгал засварын зардал 1.0, нормативт зардал 0.3, нийт 495.9 сая төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

Төвлөрүүлэх шилжүүлэг 507.5 сая, нэмэлт төсвийн санхүүжилтийн орлого 4.9 сая, нийт 512.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.



.11. Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн ерөнхий зөвлөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шүүхийн ерөнхий зөвлөл нь Шилэн дансны хуульд заасан дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шүүхийн тамгын газрууд өөрийн цахим хаяг болон www.shilendans.gov.mn сайтад шилэн дансны цэсийг холбосон. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан. 5.0 сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий бараа, ажил үйлчилгээний тушаал, шийдвэрүүдийг оруулсан байна. Жилийн эцэс, хагас жилийн санхүүгийн тайланг оруулсан байна. Тайлант хугацаанд нийт 1237 мэдээлэл оруулахаас 1227 мэдээллийг хугацаанд нь оруулж баталгаажуулан 10 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Тус Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит, санхүүгийн тайлагнал, авлага, өглөг урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар 4 зөвлөмж өгөгдсөний 3-ыг бүрэн биелүүлж, 1 зөвлөмжийг дутуу хэрэгжүүлсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 44 зөвлөмж өгөгдсөний 42 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны ШТГ-ын 469.7 сая төгрөгийн конторын барилгыг Улсын дээд шүүхэд балансаас балансад шилжүүлэхдээ 7.7 сая төгрөгийн асфальтан талбайг үлдээжээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна. Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт алдагдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, асфальтан талбайг Улсын дээд шүүхэд шилжүүлэх арга хэмжээ авах;



3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3.2 Зардалтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Харьяа ШТГ-уудад хийсэн аудитаар хөрөнгө бэлтгэхдээ холбогдох хуулийг баримтлалгүй 24.1 сая, төсвийг зохистой удирдаагүй 19.1 сая төгрөгийн өглөг, авлага үүсгэсэн, цалин хөлс зөрүүтэй бодогдсон 11.3 сая, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 10.6 сая, баяр ёслолд зарцуулсан 7.4 сая, бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн 3.0 сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Авлага, өглөгийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх, үргүй зардал гаргах;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, ажиллах;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3.3 Зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

ШЕЗ-ийн ажлын алба 302.5 сая төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй байна. Тухайлбал багаж хэрэгсэл 71.3 сая, түрээсийн зардал 41.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 23,3 сая, урсгал зардал 10.9 сая, тавилга 8.9 сая,... нийт 174.3 сая төгрөгөөр дутуу, хөрөнгө бэлтгэх 93.4 сая, БҮТЭЗ 29.2 сая, ... нийт 128,2 сая төгрөгөөр мөнгөн гүйлгээний харилцахын дүнгээс илүү бичсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5-д "төсвийн дэлгэрэнгүй ангиллыг батлах", 22 дугаар зүйлийн 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2014 оны



дугаар тушаал, 2015 оны 7 дугаар тушаалын 1-д ..."Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллыг 2 дугаар хавсралтаар..., гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Зардлын эдийн засгийн ангилал болон төсвийн гүйцэтгэлийг буруу илэрхийлэх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын тушаалын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, ажиллах;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3.4 Санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Аудит хийгдсэн санхүүгийн тайланг нэгтгэхдээ хариуцлагагүй хандсанаас мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, тайлангийн нийт үр дүн, нэмэлт санхүүжилтын дүн зөрүүтэй нэгтгэгдэн дотоод гүйлгээг цэвэрлэхдээ холбогдох материалыг дутуу бүрдүүлснээс санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд хүндрэл бий болж ихээхэн цаг хугацаа зарцуулсан болно.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, аудитын тайлангийн чанарт нөлөөлөх, хугацаа хоцрох;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, ажиллах;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,593.4	1,097.8
Авлага	29,598.4	24,011.8
Урьдчилж төлсөн зардал	10,251.0	800.9
Бараа материал	897,495.6	1,089,831.2
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	938,938.4	1,115,741.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгө	42,000,757.4	49,356,347.9
Үндсэн хөрөнгө	41,291,074.4	44,671,285.1
Биет бус хөрөнгө	709,683.0	4,685,062.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	42,000,757.4	49,356,347.9
ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН	42,939,695.8	50,472,089.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Өглөг	9,915.4	4,532.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,915.4	4,532.0
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	9,915.4	4,532.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ		
Засгийн газрын хувь оролцоо	18,428,766.6	22,365,260.5
Хуримтлагдсан үр дүн	17,415,674.2	14,878,788.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,085,339.6	13,314,508.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	42,929,780.4	50,467,557.6
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН НИЙТ ДҮН	42,939,695.8	50,472,089.6

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
Татварын бус орлого	5,281,705.1	2,706,361.5
Тусламж, санхүүжилтийн орлого	46,864,085.7	48,624,184.0
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН НИЙТ ДҮН	52,145,790.8	51,330,545.5
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
УРСГАЛ ЗАРДАЛ		
Цалин хөлс болон ажиллагсдын тэтгэмж	37,430,671.8	38,111,044.6
Татаас болон шилжүүлгийн төлбөр	345,842.8	512,357.4
Бараа, үйлчилгээний зардал	3,832,915.9	4,428,238.6
Нийгмийн хамгааллын зардал	1,506,543.8	1,030,582.1
Элэгдэл, хорогдлын зардал	3,989,634.8	3,619,510.9
Үндсэн үйл ажиллагааны бусад зардал	3,072,480.8	3,417,996.8
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	50,178,089.9	51,119,730.4
Үндсэн үйл ажиллагааны нийт ашиг/(алдагдал)	1,967,700.9	210,815.1
Үндсэн хөрөнгө борлуулсны олз (гарз)	(1,061,439.2)	(2,944,524.9)
Үндсэн бус үйл ажиллагааны орлого (зардал)-ын нийт дүн	(1,061,439.2)	(2,944,524.9)
Тайлант үеийн цэвэр ашиг/(алдагдал)	906,261.7	(2,733,709.7)

4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хүлээн авсан мөнгөн хөрөнгө:		
Татварын бус орлого	385,329.3	214,800.1
Тусламж, санхүүжилтийн орлого	47,321,097.3	48,726,734.8
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын нийт дүн	47,706,426.6	48,941,534.9
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Цалин хөлс болон ажиллагсдын тэтгэмж	37,420,153.3	38,104,020.2
Татаас болон шилжүүлгийн төлбөр	344,186.9	512,891.4
Бараа, үйлчилгээний зардал	3,775,279.4	4,453,044.6
Нийгмийн хамгааллын зардал	1,958,801.5	1,031,579.9
Үйл ажиллагааны бусад зардал	4,032,112.5	4,269,375.8
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн хөрөнгийн нийт дүн	47,530,533.6	48,370,911.9
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	175,893.0	570,623.0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Биет болон биет бус үндсэн хөрөнгө худалдан авалт	174,380.9	571,118.6
Хөрөнгө оруулалт цэвэр мөнгөн гүйлгээ		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)	1,512.1	(495.6)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	81.3	1,593.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,593.4	1,097.8

4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Засгийн газрын хувь оролцоо	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,002,844.4		41,002,844.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	1,838.5		1,838.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,004,682.9		41,004,682.9
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн үр дүн			
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал	1,925,097.5		1,925,097.5
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	42,929,780.4		42,929,780.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	105,824.3		105,824.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,035,604.7		43,035,604.7
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн үр дүн	6,229,168.8		6,229,168.8
Өмчид гарсан өөрчлөлт	3,936,493.9		3,936,493.9
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал	(2,733,709.7)		(2,733,709.7)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,467,557.6		50,467,557.6

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,593.4		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,604,771.3	48,108,385.7	(496,385.6)	99.0
УРСГАЛ ЗАРДАЛ	48,604,771.3	48,108,385.7	(496,385.6)	99.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,380,517.8	47,099,426.2	(281,091.6)	99.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,043,259.4	34,030,583.0	(12,676.4)	100.0
Үндсэн цалин	27,229,088.0	27,148,164.2	(80,923.8)	99.7
Нэмэгдэл	4,592,907.4	4,463,514.9	(129,392.5)	97.2
Унаа хоолны хөнгөлөлт	1,519,882.0	1,507,524.2	(12,357.8)	99.2
Урамшуулал	701,382.0	911,379.7	209,997.7	129.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,140,934.4	4,073,012.8	(67,921.6)	98.4
Тэтгэврийн даатгал	2,757,941.9	2,787,373.7	29,431.8	101.1
Тэтгэмжийн даатгал	345,747.6	328,564.0	(17,183.6)	95.0
ҮОМШӨ-ний даатгал	276,598.6	254,742.2	(21,856.4)	92.1
Ажилгүйдлийн даатгал	69,149.8	64,822.4	(4,327.4)	93.7
Эрүүл мэндийн даатгал	691,496.5	637,510.4	(53,986.1)	92.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,578,233.2	1,524,427.1	(53,806.1)	96.6
Гэрэл, цахилгаан	376,394.1	357,591.3	(18,802.8)	95.0
Түлш, халаалт	831,383.4	814,239.2	(17,144.2)	97.9
Цэвэр, бохир ус	111,742.2	99,095.1	(12,647.1)	88.7
Байрны түрээс	258,713.5	253,501.5	(5,212.0)	98.0
Хангамж, бараа материалын зардал	2,950,473.1	2,928,833.2	(21,639.9)	99.3
Бичиг хэрэг	1,005,760.0	1,030,869.0	25,109.0	102.5
Тээвэр, шатахуун	823,730.0	793,750.1	(29,979.9)	96.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	641,396.6	602,311.0	(39,085.6)	93.9
Ном, хэвлэл	102,000.0	95,330.4	(6,669.6)	93.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,626.5	9,280.3	(1,346.2)	87.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	366,960.0	397,181.9	30,221.9	108.2
Нормативт зардал	43,281.8	42,974.1	(307.7)	99.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл	43,281.8	42,974.1	(307.7)	99.3
Эд хогшил, урсгал засварын зардал	2,127,264.0	2,125,931.7	(1,332.3)	99.9
Багаж, техник, хэрэгсэл	784,082.1	758,022.1	(26,060.0)	96.7
Тавилга	-	24,269.9	24,269.9	
Урсгал засвар	1,343,181.9	1,343,639.7	457.8	100.0
Томилолт, зочны зардал	452,475.4	436,139.2	(16,336.2)	96.4
Дотоод албан томилолт	452,475.4	436,139.2	(16,336.2)	96.4

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,381,846.7	1,284,167.0	(97,679.7)	92.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	615,871.0	533,139.8	(82,731.2)	86.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,792.6	7,125.4	(4,667.2)	60.4
Даатгалын үйлчилгээ	601,016.3	594,574.2	(6,442.1)	98.9
Тээврийн хэрэгслийн татвар	13,084.0	10,503.9	(2,580.1)	80.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,770.7	2,239.5	(531.2)	80.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	127,000.0	126,885.8	(114.2)	99.9
Газрын төлбөр	10,312.1	9,698.4	(613.7)	94.0
Бараа үйлчилгээний бусад зардал	662,749.8	653,468.5	(9,281.3)	98.6
Бараа үйлчилгээний бусад зардал	128,600.0	128,599.5	(0.5)	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	534,149.8	524,869.0	(9,280.8)	98.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,224,253.5	1,008,959.5	(215,294.0)	82.4
Бусад урсгал шилжүүлэг	1,224,253.5	1,008,959.5	(215,294.0)	82.4
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	28,093.7	19,666.4	(8,427.3)	70.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,196,159.8	989,293.1	(206,866.7)	82.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,604,771.3	48,107,890.1	(496,881.2)	99.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,544,771.3	48,037,278.6	(507,492.7)	99.0
Улсын төсвөөс санхүүжих	48,544,771.3	48,037,278.6	(507,492.7)	99.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	60,000.0	70,611.5	10,611.5	117.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000.0	70,611.5	10,611.5	117.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,097.8	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	155	155	0	100.0
Төсвийн байгууллага	155	155	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1960	1916	-44	97.8
Удирдах ажилтан	173	173	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	1573	1486	-87	94.5
Үйлчлэх ажилтан	214	257	43	120.1
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1960	1916	-44	97.8
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	885	837	-48	94.6
Ажлын албаны албан хаагч (АА)	59	59	0	100.0
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	3	3	0	100.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	6	6	0	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	501	511	10	102.0
Улс төрийн албан хаагч (УТ)	4	4	0	100.0
Шүүгч, прокурор	502	496	-6	98.8

Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	Аудитын код:	САГ-2019/14/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага			сая төгрөгөөр	

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
						Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	9	10
1	Үндсэн хөрөнгө	1	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны ШТТ-ын 469.7 сая төгрөгийн конторын барилгыг Улсын дээд шүүхэд балансаас балансад шилжүүлэхдээ 7.7 сая төгрөгийн асфальтан талбайг үлдээжээ.	7.7	Зөвлөмж	Тамгын газрын дарга	Д.Ганбаатар
						Нягтлан бодогч	С.Оюун эрдэнэ
2	Зардал	1	Харьяа ШТТ-уудад хийсэн аудитаар хөрөнгө бэлтгэхдээ холбогдох хуулийг баримтлалгүй 24.1 сая, төсвийг зохистой удирдаагүй 19.1 сая төгрөгийн өглөг, авлага үүсгэсэн, цалин хөлс зөрүүтэй бодогдсон 11.3 сая, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 10.6 сая, баяр ёслолд зарцуулсан 7.4 сая, бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн 3.0 сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн.	75.5	Зөвлөмж	ШЕЗ-ийн дарга	Н.Лүндэндорж
						Төсвийн ерөнхий нягтлан бодогч	С.Наранбилэг
3	Зардал	2	ШЕЗ-ийн ажлын алба 302.5 сая төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй байна. Тухайлбал багаж хэрэгсэл 71.3 сая, түрээсийн зардал 41.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 23,3 сая, урсгал зардал 10.9 сая, тавилга 8.9 сая,... нийт 174.3 сая төгрөгөөр дутуу, хөрөнгө бэлтгэх 93.4 сая, БҮТЭЗ 29.2 сая, ... нийт 128,2 сая төгрөгөөр мөнгөн гүйлгээний харилцахын дүнгээс илүү бичсэн.	302.5	Зөвлөмж	ШЕЗ-ийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга	О.Амгаланбаатар
						Ахлах нягтлан бодогч	Ө.Оюунзул
4	Санхүүгийн тайлан	1	Аудит хийгдсэн санхүүгийн тайланг нэгтгэхдээ хариуцлагагүй хандсанаас мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, тайлангийн нийт үр дүн, нэмэлт санхүүжилтын дүн зөрүүтэй нэгтгэгдэн дотоод гүйлгээг цэвэрлэхдээ холбогдох материалыг дутуу бүрдүүлсэнээс санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад хүндрэл бий болж ихээхэн цаг хугацаа зарцуулсан.		Зөвлөмж	ШЕЗ-ийн дарга	Н.Лүндэндорж
						Төсвийн ерөнхий нягтлан бодогч	С.Наранбилэг



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.